



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 5/04

Бор-Өндөр

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйл, 51.1.4 дэхь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нягтлан бодогч М.Мөнхцэцэг нь эрхэлсэн ажил үр дүнтэй хийж гүйцэтгэн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт авсан тул 1 сарын цалинтай тэнцэх урамшуулал олгосугай.
2. Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж үр дүнтэй ажилласан хөгжмийн багш А.Тэргэл, бүжгийн багш М.Соёлсүвд, ОНСТ ажилтан Б.Энх-Амар нарт ажлын үр дүнг харгалзан ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувиар тус тус тооцож олгосугай.
3. Дээрх ажилчдын урамшуулалыг холбогдох зардлаас зохих хууль, дүрэм, журмын дагуу олгохыг нягтлан бодогч /М.Мөнхцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА М.ЧУЛУУНЦЭЦЭГ

